



**ОРХОН АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТОГТООЛ**

2020 оны 11 сарын 30 өдөр

Дугаар 02/03

Эрдэнэт

Газрын харилцааны талаар  
2021 онд баримтлах үйл ажиллагааны  
чиглэл батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль"-ийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэг, 18 дугаар зүйлийн 18.1.2"з" дэх хэсэг, Газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.2 дахь заалт, Хот байгуулалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.3 дахь заалт, Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1.Газрын харилцааны талаар 2021 онд баримтлах үйл ажиллагааны чиглэлийг нэгдүгээр, аж ахуйн зориулалтаар иргэн, аж ахуйн нэгжид шинээр эзэмшүүлэх, ашиглуулах газрын байршил, хэмжээг хоёрдугаар, гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар үнэгүй өмчлүүлэх газрын байршил, хэмжээг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Энэхүү тогтоолын биелэлтийн явцыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд хагас жилээр, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралдаанд бүтэн жилээр тайлагнахыг аймгийн Засаг дарга С.Батжаргалд даалгасугай.

ДАРГА



Д.МӨНХБАТ



ГАЗРЫН ХАРИЛЦААНЫ ТАЛААР 2021 ОНД БАРИМТЛАХ  
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ

Нэг.Газар зохион байгуулалтын чиглэлээр:

1.1.Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг /2021-2037 он хүртэлх/ мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэн батлуулах.

1.2.Газрын эрхийн бүртгэлийн LandManager 2 программ хангамжийн мэдээллийн санд нэгж талбарын анхны эзэмшигч, өмчлөгчийн мэдээлэл, өгөгдлүүдийг бүртгэх ажлыг хийж дуусгах

1.3.Аймгийн нутаг дэвсгэрт орших геодезийн сүлжээний цэгүүдэд үзлэг тооллого хийж, гэмтсэн болон устсан цэгүүдийн судалгааг гаргаж, нөхөн сэргээх ажлыг үе шаттай зохион байгуулах

1.4.Газрын цахим бирж, Хот байгуулалтын кадастрын мэдээллийн сан, Газарзүйн мэдээллийн сан зэрэг улсын хэмжээнд шинээр хийгдэж буй онлайн горимд ажилладаг цахим мэдээллийн сангуудын үйл ажиллагааг нийтэд сурталчлах, танилцуулах ажлыг хийх

1.5.Суурьшлын бүсийн газруудад төлөв байдал, чанарын хянан баталгааны дүгнэлт гаргах ажлыг мэргэжлийн байгууллагаар хийж гүйцэтгүүлэн хүлээн авах.

1.6.Газрын болон Хот байгуулалтын хуулиудыг зөрчсөн гэм буруутай нь тогтоогдсон иргэн, хуулийн этгээдийн газар эзэмших эрхийг хүчингүй болгох, шаардлагатай тохиолдолд газрыг албадан чөлөөлөх ажлыг тухай бүр нь зохион байгуулах.

1.7.Иргэдэд төрийн үйлчилгээг түргэн шуурхай хүргэх зорилгоор цахим хэлбэрт шилжүүлэх боломжтой үйлчилгээний төрлийг сонгож, цахимаар үйлчлэх шийдлийг боловсруулах

Хоёр.Барилга, хот байгуулалтын чиглэлээр:

2.1.Хот байгуулалтын кадастрын мэдээллийн санд мэдээлэл бүртгэх ажлыг үргэлжлүүлэн хийж, дутуу мэдээллийг бүрэн оруулах.

2.2.Хаягжуулалтын тухай хуулийн дагуу Эрдэнэт хотын гудамж, талбайн нэр, эд хөрөнгийн хаягжуулалтын зургийг Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлттэй уялдуулан боловсруулж, батлуулах

2.3.Дахин төлөвлөлт хийгдэхээр сонгогдсон байршлуудад төсөл хэрэгжүүлэгчийг сонгон шалгаруулах ажлыг зохих журмын дагуу зохион байгуулах

2.4.Барилгын материалын сорилт шинжилгээний лабораторит шаардлагатай багаж, тоног төхөөрөмжийг нэмж авах.




Аймгийн ИТХ-ын 2020 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн Ээлжит II хуралдааны 02/03 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралт

Аж ахуйн зориулалтаар иргэн, аж ахуйн нэгжид шинээр эзэмшүүлэх, ашиглуулах газрын байршил, хэмжээ

№	Төлөвлөлтийн нэгж талбарын дугаар	Газрын зориулалт /ГНС-ын ангиллаар/	Хаяг /Баг, хороо/	Байршил /газрын нэр, гудамж/	Талбайн солбицол		Төлөвлөсөн талбайн хэмжээ /м.кв/	Хэрэгжүүлэх хугацаа /улирлаар				Хариуцах эзэн	Тайлбар
					Х	Ү		I	II	III	IV		
1	1849383	Худалдаа, үйлчилгээ	Баянцагаан	Эрдэнэт Өртөөний хойд талд	438715.806 438727.308 438755.190 438743.688	5434615.016 5434594.595 5434610.299 5434630.720	750					ГХБХБГ	Дуудлага худалдаагаар эзэмшүүлнэ.
3	1849384	Худалдаа, үйлчилгээ	Баянцагаан	Эрдэнэт Өртөөний хойд талд	438755.190 438727.308 438738.810 438766.691	5434610.299 5434594.595 5434574.174 5434589.877	750					ГХБХБГ	
4		Орон сууц	Говил	Илгээлтийн хэсэг	435616.321 435656.013 435678.635 435623.919	5434115.196 5434132.516 5434066.604 5434061.251	3000					ГХБХБГ	
5	1849385	Үйлдвэр	Баянцагаан	"Мах маркет" ХХК-ийн эзэмшил газрын зүүн хойд талд			3000					ГХБХБГ	
6		Худалдаа, үйлчилгээ	Их залуу	15-р сургуулийн хойд талд			1000					ГХБХБГ	
7		Үйлдвэрлэл	Баянцагаан	Мах маркетын урд талд			3500					ГХБХБГ	
8		Зочид буудал	Уурхайчин	Цэнгэлдэх хүрээлэн			13000					ГХБХБГ	
9		Худалдаа үйлчилгээ	Цагаанчулу ут	Танил захын баруун талд	428379.8 428418.9 428441.1 428401.2	5429852 5429866 5429796 5429784	3000					ГХБХБГ	
10		Худалдаа үйлчилгээ	Цагаанчулу ут	Танил захын баруун талд	428379.8 428401.2 428373.7 428353.1	5429852 5429784 5429776 5429843	2000					ГХБХБГ	
	<b>Дүн</b>						<b>30000</b>						



Аймгийн ИТХ-ын 2020 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн Ээлжит II хуралдааны 2/103 дугаар тогтоолын гуравдугаар хавсралт



Гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар үнэгүй өмчлүүлэх газрын байршил, хэмжээ

No	Аймаг	Сумын нэр	Өмчлөх газрын байршил	Өмчлүүлсэн газрын хэмжээ /га/										Өмчлүүлсэн иргэдийн тоо								
				Иргэдэд өмчлүүлсэн газрын нийт хэмжээ /га/	Иргэдэд үнэгүй өмчлүүлсэн нийт хэмжээ	Үүнээс			Аж ахуйн зориулалтаар өмчлүүлэх иргэдийн тоо	Үүнээс			Газар өмчлүүлсэн нийт иргэдийн тоо	ГЕХ үнэгүй өмчлүүлсэн иргэдийн тоо	Одоо эзэмшиж байгаа газраа өмчлүүлсэн /га/	Шинээр газар өмчлүүлсэн	Улсын чанартай авто замын дагуу өмчлүүлсэн аж ахуйн зориулалтаар өмчлүүлсэн газрын нийт хэмжээ	Үүнээс				
						Одоо эзэмшиж байгаа газраа өмчилсэн	Шинээр газар өмчлүүлсэн	Улсын чанартай авто замын дагуу өмчлүүлсэн		Үр тарианы	Төмс хүнсний ногоо	Газар тариалангийнхаас бусад						Үр тарианы	Төмс, хүнсний ногоо	Газар тариалангийнхаас бусад		
0	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17	18	19	20		
1	Орхон	Баян-Өндөр	Баянбулаг	0.8	0.8	0.8						10	10	10								
2			Булаг	0.8	0.8	0.8							10	10	10							
3			Цагаанчулуут	1	1	1								10	10	10						
4			Рашаант	0.8	0.8	0.8								10	10	10						
5			Наран	0.8	0.8	0.8								10	10	10						
6			Шанд	0.8	0.8	0.8								10	10	10						
7			Их залуу	1.6	1.6	0.8	0.8							20	20	10	10					
8			Дэнж	3	3	1	2							40	40	10	30					
9			Эрдэнэ	12	12		12							150	150		150					
10			Говил	8	8		8							100	100		100					
11			Баянцагаан	1.6	1.6		1.6							20	20		20					
12			Уртын гол	3.2	3.2		3.2							40	40		40					
13			Яргуйт	14	14		14							180	180		180					
14			Даваат	2	2		2							30	30		30					
15			Хүрэнбулаг	1	1	1								30	30	30						
		<b>Нийт</b>	<b>51.4</b>	<b>51.4</b>	<b>7.8</b>	<b>43.6</b>						<b>670</b>	<b>670</b>	<b>110</b>	<b>560</b>							
16	Жаргалант	Улаантолгой	2	2	1	1						25	25	12	13							
17		Жаргалант	1.5	1.5	0.5	1						18	18	6	12							
		<b>Нийт</b>	<b>3.5</b>	<b>3.5</b>	<b>1.5</b>	<b>2</b>						<b>43</b>	<b>43</b>	<b>18</b>	<b>25</b>							
18		<b>Бүгд нийт</b>	<b>54.9</b>	<b>54.9</b>	<b>9.3</b>	<b>45.6</b>						<b>713</b>	<b>713</b>	<b>118</b>	<b>585</b>							